

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

НШУС

№ 12/370

2011

ХЯТАД УЛС ДАХЬ МОНГОЛ ХЭЛНИЙ НЭР ТОМЬЁОНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Чэн Нарантунгалаг*

* Өвөр Монголын Их Сургуулийн магистрант

Түлхүүр уг: Өвөр Монголын нэр томьёоны комисс, нэр томьёоны албан мэдээ, Монголын хэл бичиг судлах хурал, соёлын их хувьсгал

Нэг. Монгол хэлний нэр томьёоны комисс

Орчин үеийн нийгмийн хөгжил Монгол хэлэнд судалгаа шинжилгээний олон төрлийн нэр томьёо шаардагддаг болжээ. Олон жилийн турш эдгээр Монгол хэлний нэр томьёоны нэрлэж тогтоох, дүрэмжүүлж нэгтгэх болон хэрэгжүүлэх ажлыг Өвөр Монголын Монгол хэлний нэр томьёоны комисс хариуцаж хийсээр иржээ.

Монгол хэлний нэр томьёоны ажил өнгөрсөн зууны 50-иад оноос эхэлсэн түүхтэй. 1953 оны 7-р сарын 1-ний өдөр Өвөр Монголын Сүюэн хувиар товчооноос "Үндэсний хэл бичгийн үл хайрах хэлбэрийг эсэргүүцэх болон үндэсний хэл бичгийн ажлыг цаашид улам чангатгах тухай" заавар гаргасныг БНХАУ нь Монгол хэлний нэр томьёоны ажлын шинэ хуудсыг нээж, Монгол хэлний нэр томьёоны засаггүй байдлыг өөрчилж, энэ ажлыг нам засгаас эзэмшин хамаарч, зохион байгуулалтыг эрхшээлд нь оруулж, Монгол хэлний ажлын зохион байгуулалт — Өвөр Монголын хэл бичиг судлах хурал жич түүний зэрэг дэс, ажилчны орон тоо, үүрэг хариуцлагыг нарийн тодорхой тогтоож өгснөөр барахгүй Монгол

хэлний нэр томьёог нэгтгэхийг гол үүргээ болгосон¹ билээ.

1954 оны 6-р сард тус зааврын үзэл санаагаар Өвөр Монголын хэл бичиг судлах хурлын нэр томьёог нэгтгэх комисс, шинэ үсгийн тухай асуудлыг судлах комисс, орчуулга ба хэл зүйг судлах комисс, Монгол хэл бичиг сэтгүүлийн найруулгын комисс, Монгол бичиг уг материалыудын цуглуулан нэгтгэх комисс зэрэг 5 комиссийг байгуулжээ. 1959 онд нэр томьёоны комиссоос анхны Монгол хэлний нэр томьёог нэгтгэх, зохиох зарчим ба аргыг боловсруулан гаргаж, Монгол хэлний нэр томьёоны "албан мэдээ"-г нийтлүүлсэн байна. 1957 оны сүүлээр Монгол хэлний нэр томьёоны ажилд "зүүн"-ий харш үзэл саад учруулж, Монгол хэлний нэр томьёоны ажил зогсонгүй байдалд орсон ажээ. "Соёлын их хувьсгал"-ийн үед Монгол хэлний нэр томьёоны ажил тодорхой хугацаагаар зогссон байна. Хятад хэлнээс нэр томьёо зээлэх ба хятад хэлний үгийг шууд авиаачлан тэмдэглэх оролдлого 1965-1972 онд явагдаж, "Соёлын их хувьсгал"-ын дунд үед туйлдаа хүрч, Монгол хэл ба Монгол хэлний нэр томьёог ихээхэн эмх замбараагүй байдалд оруулсан ажээ. Энэ бүхэн нь Монгол хэлний нэр томьёоны ажилд туйлын их хохирол учруулсан юм². 1972 оны 7-р сард Өвөр Монголын Өөртөө Засах орны Монгол хэлний

ажлыг удирдах дугуйлан байгуулагдсаны дараа монгол хэлний нэр томьёоны ажил дахин сэргэж эхэлсэн түүхтэй. 1976 онд найман мужийн Монгол хэл бичгийн хамтын ажиллагааны дугуйлангаас монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн хурлыг хоёр удаа хуралдуулж, монгол хэлний нэр томьёоны ажлын эмх замбараагүй байдлыг гэтлэх тал дээр ихээхэн амжилтанд хүрчээ. 1977 онд монгол хэлний нэр томьёоны ажлыг найман муж орны Хамтын ажиллагааны дугуйлангийн удирдлага доор нэр томьёог хянан тогтоох ажлыг улам эрчимтэй явуулж, монгол хэлний тусгай мэргэжлийн хурлыг хоёр удаа хуралдуулсны үр дүнд нийт 581 нэр томьёог хянан нэгтгэжээ.

1982 оны 9-р сард Өвөр Монголын өөртөө засах орны монгол хэлний нэр томьёоны ажлын хурлыг хуралдуулж, шинэ уг, нэр томьёог хянан тогтоох дүрэм тогтоол зэргийг гаргаж, Засгийн ордоон зөвшөөрүүлж, хэрэгжүүлснээр монгол хэлний нэр томьёоны ажил дахин нилээд эрчимтэй явагдах болов. "Өвөр Монголын өөртөө засах орны нэр томьёоны комисс бол өөртөө засах орны хэл бичгийн зөвлөлийн удирдлага дор бүх орны монгол хэлний нэр томьёоны хянан нэгтгэх ажлыг хариуцах бөгөөд бүх орны монгол хэлний нэр томьёоны хэрэглэх байдлыг байцаан шаардана. Монгол хэлний нэр томьёоны албан мэдээг найруулан хэвлүүлж тогтсон хугацаатайгаар хянан нэгтгэсэн нэр томьёог бүх оронд зарлана. Манай орны жинхэнээр хэвлүүлэх монгол хэлний нэр томьёоны эмхтгэл ба олон төрлийн толь бичиг дэх нэр томьёоны хяналтыг хариуцна. Нэр томьёоны эрдэм шинжилгээний хурлыг хуралдуулж, гадаад дотоодын нэр томьёоны материал ба мэдээ мэдээллийг нэгтгэн цуглуулах ажлыг хариуцаж, нэр томьёоны зарчим аргыг судлан тогтооно. Нэр томьёоны судалгааны ажлыг хөгжүүлэн дээшлүүлэх болно"³ гэж комиссийн зорилго,

үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдал.

1991 оны 10-р сард найман муж орны монгол хэлний салбарт хамтран ажиллаж байгаа бодит шаардлагыг үндэслэж, Өвөр Монголын нэр томьёоны комиссийн суурин дээр найман муж орны нэр томьёоны комиссийг байгуулжээ. Мөн хамтран ажиллаж байгаа муж бүрт монгол хэлний нэр томьёоны бага дугуйлан байгуулж, монгол хэлний комиссийн гишүүд тус дугуйлангийн даргын тушаалыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэдгээрийн гол үүрэг нь нэр томьёог цуглуулах, эмхэтгэх, хянах ба дүрэмжүүлэх байв. Бас албан мэдээний хэлбэрээр найман муж оронд тараах ажлыг хэрэгжүүлэх болов. Нэр томьёоны комиссийн гишүүд нь нам засгийн орчуулах газар, сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо, сонин мэдээ сэтгүүлийн хороо зэрэг олон төрлийн шинжилгээний нэгж байгууллагын мэргэжилтэн ба засгийн ордны гишүүдээс бүрдсэн байна.

БНХАУ нь ойрын хэдэн жилд монгол хэлний нэр томьёоны комиссийн үйл ажиллагаа, монгол нэр томьёоны тухай онолын асуудлыг чухалчилж, эрдэм шинжилгээний хурлыг жилд 1-2 удаа хуралдуулсаар ирсэн бөгөөд хуралд хэлэлцүүлсэн зарим өгүүллийг "Өвөр Монголын өдрийн сонин" ба "Монгол хэл бичиг" зэрэг сонин, сэтгүүлд нийтлүүлж байна. Тэдгээр өгүүллүүд монгол хэлний нэр томьёоны хөгжиж ирсэн түүхэн үйл явц ба цаашид баримтлах онолын үзэл баримтлал, зарчим, арга зүйн асуудлуудыг тусгаснаараа ач холбогдолтой юм.

Mонгол хэлний нэр томьёоны комисс нь байгуулагдаад хэдийгээр 50 гаруй жил болж байгаа боловч монгол хэлний нэр томьёог баримжаалах ажил өнгөрсөн зууны 90-ээд оноос эрчимтэй эхэлсэн гэж үздэг. Энэ хугацаанд нэр томьёог эмхэтгэн цуглуулж, хянан тогтоох ажилд ахиц дэвшил цөөнгүй байсан ч мөн багагүй дутагдал байсаар байна.

Үүний шалтгаан нь: нэгдүгээрт: Улсын зүгээс үзүүлэх тус дэмжлэг, хөрөнгө оруулалт хэрэгцээ шаарлагын төвшинд хараахан хүрч чадаагүй юм. Хоёрдугаарт: Монгол хэлний нэр томъёоны ажлыг хариуцан хийж байгаа ажилтан цөөн байв. Гуравдугаарт: нийгмийн дэмжлэг сул, мэргэжлийн судлаачдын тоо цөөн байсантай холбоотой юм⁴.

Хоёр. Монгол хэлний нэр томъёоны албан мэдээ

Монгол хэлний нэр томъёоны албан мэдээ бол Өвөр Монголын Өөртөө засах орон болон бүх Хятад Улсын монгол хэлэнд нэгтгэх ба олон төрлийн монгол хэлний сурах бичиг, монгол сонин сэтгүүл, ном хэвлэлийн үг хэллэгийн дүрмийг сайжруулахад маш чухал ач холбогдолтой юм.

1959 онд Өвөр Монголын Өөртөө засах орны хэл бичгийн ажлын зөвлөлөөс "Монгол хэлний шинэ нэр томъёог тогтоох ба нэгтгэх тухай хэдэн арга"-ыг тогтоож, нийтлэхийн хамт бас нэгтгээгүй нэр томъёо ба зарим шинэ үгсийн орчуулгыг хянан тогтоох зорилгоор монгол хэлний нэр томъёоны албан мэдээг анх нийтлэв. Монгол хэлний нэр томъёоны ажлыг Өвөр Монголын Өөртөө засах орны Засгийн ордны ажлын зөвлөлөөс хариуцан хийж байгаа бөгөөд албан мэдээний хэлбэрээр нийтлэн хэрэгжүүлдэг. Засгийн газраас орон даяар монгол хэлний нэр томъёоны цуглуулах, эмхэтгэх, орчуулга хийх, ярилцах, санал авах, хянан тогтоох, нийтлэх зэрэг бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

2008 онд байгалийн шинжлэх ухааны нэр томъёог дүрэмжүүлэхийн тулд найман муж орны нэр томъёоны комиссийн харьяанд шинжлэх ухааны нэр томъёоны салбар зөвлөлийг байгуулжээ. Энэ зөвлөл нь Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороод байршдаг бөгөөд гишүүд нь Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хорооноос голлон бүрддэг. Мөн Өвөр Монголын их сургууль, Өвөр

Монголын багшийн их сургууль, Өвөр Монголын тариалингийн их сургууль зэрэг нөлөө бүхий их, дээд сургуулиудын мэргэжлийн багш нар энэ зөвлөлийн гишүүнээр ажилладаг. Тус техникийн мэргэжилийн албан мэдээ гаргаж тараадаг.

2011 он хүртэл энэхүү албан мэдээний нийт 110 дугаар хэвлэгдэн гарч, 20000 гаруй шинэ үг, нэр томъёог дүрэмжүүлжээ. Бас хятад, монгол хэлний харьцуулсан тусгай мэргэжлийн нэр томъёог хянаж батлаад цуврал бичгийн хэлбэрээр 35 удаа нийтэлжээ. Үүнд гүн ухаан, хууль цааз, шашин, улс төр, эдийн засаг, хүн ам зүй, дотоодыг хамгаалах аж үйлдвэрлэл, тоо бүртгэл, мөнгөн гүйлгээ, сурган хүмүүжүүлэх, сэтгэл зүй, логик, үг хэл, үсэг бичиг, утга зохиол, түүх, номын сан, бүжиг, биений тамир, газар зүй, математик, физик, хими, ургамал судлал, амьттан судлал, анагаах ухаан, зам харилцаа, холбоо, зураг төлөвлөх, хил гааль, цахилгаан мэдээ, мэдээлэл зүй зэрэг шинжлэх ухааны салбарын бүхий л шинжилгээний нэр томъёог хамран оруулахыг зорилго болгосноороо онцлогтой юм.

Гурав. Монгол хэлний нэр томъёог баримжаалах ажил

Нэр томъёог баримжаалах ажил бол шинжлэх ухаан техникийн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёог тогтоох, нийтлэх, хэрэгжүүлэхээр дамжуулж, түүний ямар нэгэн баримжаанд нийцүүлж, нийгэм нийтийн солилцоог ахиулах ба хүмүүсийн олон төрлийн хэрэглээний нэгтгэх ажиллагаа мөн⁵.

Hэр томъёог баримжаалах ажил бол монгол хэлний ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тус ажил нь шинжлэх ухаанч чанар, төрийн бодлогот чанараар чанга байдаг бөгөөд үүнийг сайн хийх нь үндэсний булгэмд ашигтай. Монгол үндэстэн нь өөрийн үг хэлээ өргөн хүрээнд хүртээмжтэй хэрэглэх, оновчтой зээм-

шихэд тустай гэдэг нь тодорхой. Монгол хэлний нэр томъёоны ажил нь өнөөдөр нэгэнтээ 60-аад жилийг өнгөрөөж, нилээд үр өгөөжтэй, бүтээмжтэй явж байна. Энэ нь монгол хэлний нэр томъёоны дүрэмжүүлэлтийн ажлын бат бөх үндэс суурийг тавьж өгсөн гэж хэлж болно. Монгол хэлний нэр томъёог баримжаалах ажлыг алхам алхмаар урагшлуулахын төлөө бүх улсын нэр томъёог баримжаалах ажлын зөвлөлийн цөөн тоот үндэстний онцгой салбар зөвлөлийн шаардлагаар монгол хэлний нэр томъёог баримжаалах ажлын зөвлөлийг байгуулсан юм. 1997 оны 9-р сард Улсын монгол хэлний нэр томъёог баримжаалах ажлын хурал хуралдсан бөгөөд монгол хэлний нэр томъёог баримжаалах ангийг байгуулсан байна. Мөн "Монгол хэлний нэр томъёоны энгийн зарчим ба арга", "Монгол хэлний нэр томъёоны товчлон бичих бичлэгийн энгийн зарчим ба арга", "Монгол хэлний толь бичгийн найруулгын энгийн зарчим ба арга" зэргийг тогтоож, гурван жилийн судалгаа ба санал авах, дахин засвар оруулахаар тогтжээ. 1998 онд Өвөр Монголын Өөртөө засах орон нутгийн баримжаа DB15/T293/1998 "Монгол хэлний нэр томъёог хянан тогтоох энгийн зарчим ба арга" ба DB15/T294/1998 "Монгол хэлний нэр томъёог найруулан бичих тогтоол"-ыг нийтэлж, 2000 онд Улсын чанарыг хянах товчоонаас "Монгол хэлний нэр томъёоны ажлын зарчим ба арга" GB/T18291/2000 зэрэг улсын баримжааг нийтэлжээ. 2001 онд Өвөр Монголын чанар, мэргэжлийг хянах товчоонаас "Монгол хэлний нэр

томъёоны товчилсон үгийн зарчим ба арга", "Монгол хэлний толь бичиг найруулах ажлын зарчим ба арга"-ыг боловруулж нийтэлсэн байна. Мөн 2006 онд "Монгол хэлний толь бичиг найруулгын ажлын зарчим ба арга"-ын улсын баримжааг хянан тогтоожээ. 2007 оны 1-р сард "Монгол хэлэн дэх гадаад нэр томъёоны [англиас орж ирсэн үгийн] бичлэгийн арга" гэсэн судалгааны сэдвийг хянан тогтоож олны хүртээл болгожээ. Хэдийгээр энэ

нь тус судалгааны сэдвийн нэр томъёог баримжаалах албан дүрэм биш боловч, тэр нь баримжаалах ажилд чухал баримт бичиг болсон байна. Түүнд англиас орж ирсэн үгний монгол хэлэн дэх бичлэгийн хэлбэрийг дүрэмтэй болгосноор барахгүй цаашид харь хэлнээс орж ирсэн үг болон нэр томъёоны

дүрмийн судлалд маш чухал лавлах болохын хамт судалгаа, шинжилгээний ажилд өндөр ач холбогдолтой болжээ.

2007 оны 10-р сард "Монгол хэлний нэр томъёоны сан хөмрөг"-т 22 төрлийн шинжилгээний нэр томъёо, 300000 гаруй нэр томъёог нийтэлж, Хятадын нэр томъёоны сан хөмрөгийг баяжуулжээ. Тус сан хөмрөг бол БНХАУ-ын цөөн тооны үндэстний хамгийн анхны нэр томъёоны сан хөмрөг болсноороо онцгой ач холбогдолтой юм Ийм сан хөмрөг байгуулагдсан нь монгол хэлний нэр томъёоны ажлыг шуурхайлж, монгол хэлний нэр томъёоны судалгааны ажлыг нэг алхам урагшлуулахад нөлөөлжээ.

Үүнээс гадна 2000 оноос хойш "Хятад-Монгол толь" (нэмж засварласан), "Хятад, Монгол шинэ үсгийн толь

«
Нэр томъёог баримжаалах ажил
бол шинжслэх ухаан техникийн
мэргэжлийн уг хэлэг, нэр томъёог
тогтоох, нийтлэх, хэрэгжүүлэхээр
дамжуулж, түүний ямар нэгэн
баримжаанд нийцуулж, нийгэм
нийтийн солилцоог ахиулах ба
хүмүүсийн олон төрлийн
хэрэглээний нэгтгэх ажиллагаа мөн.
»

»

бичиг", "Хятад, Монгол шинэ үгийн тайлбар толь бичиг", "Хятад-Монгол толь" (2012 онд хэвлэгдэнэ), "Шинэ нэр толь" томъёоны толь", "Шинэ үг, нэр томъёо" (2005 он), "Монгол нэр томъёоны өгүүллүүд" (2 боть, 1911 онд анх удаа, 1999 онд 2 дахь удаа хэвлэгдсэн) хэвлэгдсэн нь монгол хэлний нэр томъёог баримжаалах ажилд чухал бүтээл болжээ.

Ишлэл

¹ 1991. Монгол нэр томъёоны өгүүллүүд (I боть), Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо, 1-4 дэх тал.

² 2008. Монгол хэлний нэр томъёоны судлал. Үндэстний хэвлэлийн хороо. 7-р сар, 41 дэх тал.

³ Баатар Д. 2008. Монгол хэлний нэр томъёоны судлал. Үндэстний хэвлэлийн хороо, 7 сар, 424 дэх тал.

⁴ Өвөр Монголын нэр томъёоны комиссийн эрхлэгч Хишигдүүрэнтэй хийсэн ярилцлага. 2011 оны 9-р сарын 8-ны өдөр.

⁵ Өвөр Монголын өөртөө засах орны Монгол хэл бичгийн ажлын данс эвхмэл.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баатар Д. 2008. Монгол хэлний нэр томъёоны судлал. Үндэстний хэвлэлийн хороо. 7-р сар.

2. 2005. Монгол хэлний нэр томъёоны өгүүллүүд. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 12-р

сар.

3. 1991. Монгол нэр томъёоны өгүүллүүд (I боть), Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо.

4. 2008. Монгол хэлний нэр томъёоны судлал. Үндэстний хэвлэлийн хороо. 7-р сар.

5. Өвөр Монголын Өөртөө засах орны Монгол хэл бичгийн ажлын данс эвхмэл.

6. Өвөр Монголын нэр томъёоны комиссийн эрхлэгч Хишигдүүрэнтэй хийсэн ярилцлага. 2011 оны 9-р сарын 8-ны өдөр.

7. Хичээлт С. 2007. Монгол хэлний нэр томъёоны ажлын эргэцүүлэл хийгээд нэр томъёоны орчуулгын судлал (хятад хэл дээр). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 8-р сар.

Summary

This article discusses the importance of Mongolian terminologies in China, their working, naming principles and developmental processes. The article consists of three parts. First part discusses the history of definitions of Mongolian terminologies in China and their current problems. Second part discusses the problems of communication and publication of Mongolian terminologies in China. Third part discusses the problems of standardization of Mongolian terminologies in China and the construction of the terminology database and also it discusses current situation of Mongolian terminology of cultural values and their results.